



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

Захиргааны хэл нэмэлт
эргэн улсын нэгдсэн сонд
2020 оны 01 сарын 20-ны
өдрийн 4650 дугаарт бүртгээ.

2019 оны 12 сарын 31 өдөр

Дугаар 302

Улаанбаатар хот

Аргачлал, журам батлах тухай


Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.6 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн үнэлгээ тооцох, татварын ногдлыг тодорхойлох аргачлал”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл бэрлуулсан, шилжүүлсний орлогод албан татвар ногдуулах журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Татварын ерөнхий газар /Б.Заяабал/-т үүрэг болгосугай.


3. Тушаалыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан арга зүйгээр хангаж ажиллахыг Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар /Ж.Ганбат/-д даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Аргачлал батлах тухай” Сангийн сайдын 2017 оны 380 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Ч.ХҮРЭЛБААТАР

САНГИЙН ЯАМНЫ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Бүртгэлийн №... 208
Энгийн захиргааны удирдлагын газрын дэргэ
Хууль эрх зүйч
2019.12.31 өдөр



АШИГТ МАЛТМАЛ, ЦАЦРАГ ИДЭВХТ АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛ, АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ҮНЭЛГЭЭ ТООЦОХ, ТАТВАРЫН НОГДЛЫГ ТОДОРХОЙЛОХ АРГАЧЛАЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү аргачлалын зорилго нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.8, 30.6-д заасан эцсийн эзэмшигч, хуулийн этгээдийн ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл борлуулсан, шилжүүлсний орлогод албан татвар ногдуулах үнэлгээ тооцох, татварын ногдлыг тодорхойлоход оршино.

Хоёр. Тусгай зөвшөөрлийн үнэлгээг тооцох арга

2.1. Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн үнэлгээг татвар төлөгчийн мэдүүлсэн гэрээний үнэ болон доор дурдсан аргыг¹ ашиглан тооцно. Үүнд:

- 2.1.1. өртөгт суурилсан арга;
- 2.1.2. зах зээлд суурилсан арга;
- 2.1.3. орлогод суурилсан арга.

Гурав. Хайгуулын тусгай зөвшөөрлийн үнэлгээ тооцох

3.1. Харилцан хамааралтай этгээдэд борлуулсан, шилжүүлсэн хайгуулын тусгай зөвшөөрлийн үнэлгээг доор дурдсаны дагуу тооцсон үнэлгээ ба татвар төлөгчийн мэдүүлсэн гэрээний үнийн аль өндрөөр тооцно:

3.1.1. Ашигт малтмалын тухай хуульд заасан хайгуулын зардлын доод хэмжээний нийт дүнгээс тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хайгуулын зардлын дүн энэ аргачлалын 3.4-т заасан хувиас илүүгүй тохиолдолд зах зээлд суурилсан болон өртөгт суурилсан аргаар тооцсон үнэлгээний дундаж;

3.1.2. хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай дахь ашигт малтмалын нөөцийн хэмжээ А, В² зэргээр Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр батлагдсан тохиолдолд орлогод суурилсан аргаар тооцсон дүн;

3.1.3. энэ аргачлалын 3.1.1, 3.1.2-т зааснаас бусад тохиолдолд өртөгт суурилсан аргаар тооцсон дүн.

3.2. Харилцан хамааралгүй этгээдэд борлуулсан, шилжүүлсэн хайгуулын тусгай зөвшөөрлийн үнэлгээг татвар төлөгчийн мэдүүлсэн гэрээний үнэд үндэслэн тооцно.

¹ Энэ аргачлалын 2.1-д заасан аргыг энэ аргачлалын 5, 6, 7 дугаар зүйлд дэлгэрэнгүй тайлбарласан болно.

² Уул уурхайн сайдын 2015 оны 203 дугаар тушаалаар батлагдсан "Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар"-ын дагуу тодорхойлсон нөөцийн зэрэг

3.3.Энэ аргачлалын 3.2-т зааснаар татвар төлөгчийн мэдүүлсэн гэрээний үнэ нь доор дурдсаны дагуу тооцсон үнэлгээнээс 20 ба түүнээс дээш хувиар бага тохиолдолд энэ заалтад заасан аргачлалын дагуу тодорхойлсон дүнгээр тусгай зөвшөөрлийн үнэлгээг тооцно:

3.3.1.Ашигт малтмалын тухай хуульд заасан хайгуулын зардлын доод хэмжээний нийт дүнгээс тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хайгуулын зардлын дүн энэ аргачлалын 3.4-т заасан хувиас илүүгүй тохиолдолд зах зээлд суурилсан болон өртөгт суурилсан аргаар тооцсон үнэлгээний дундаж;

3.3.2.хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай дахь ашигт малтмалын нөөцийн хэмжээ А, В зэргээр Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр батлагдсан тохиолдолд орлогод суурилсан аргаар тооцсон дүн;

3.3.3.энэ аргачлалын 3.3.1, 3.3.2-т зааснаас бусад тохиолдолд энэ аргачлалын 2.1.1-т заасан аргаар тооцсон дүн.

3.4.Татвар төлөгчийн гаргасан хайгуулын зардлын нийт дүнг Ашигт малтмалын тухай хуульд заасан хайгуулын зардлын доод хэмжээний нийт дүнтэй харьцуулах хувь:

3.4.1.Хайгуулын тусгай зөвшөөрлийн эхний 3 жилд 100 хувь;

3.4.2.Хайгуулын тусгай зөвшөөрлийн 4-6 дахь жилд 50 хувь;

3.4.3.Хайгуулын тусгай зөвшөөрлийн 7-9 дэх жилд 30 хувь;

3.4.4.Хайгуулын тусгай зөвшөөрлийн 10-12 дахь жилд 20 хувь байна.

3.5.Татвар төлөгч нь хайгуулын тусгай зөвшөөрлийн гэрээний үнэ болон энэ аргачлалд заасан тусгай зөвшөөрлийн үнэлгээ тооцох аргын дагуу тооцсон тооцоолол, холбогдох баримт бичгийг татварын албанд мэдүүлнэ.

3.6.Энэ аргачлалын дагуу татвар төлөгчөөс ирүүлсэн тусгай зөвшөөрлийн үнэлгээний тооцооллыг татварын алба хянана.

3.7.Ашигт малтмалын тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн тодорхой хэсгийг шилжүүлэх тохиолдолд энэ аргачлалын дагуу тооцсон үнэлгээнээс нэгж талбай, эсхүл нэгж нөөцөд ногдох үнэлгээг тооцон, хэсэгчлэн шилжүүлж буй талбайн хэмжээ эсхүл нөөцийн хэмжээгээр үржүүлэн хэсэгчлэн шилжүүлэх талбайн үнэлгээг гаргана.

3.8.Энэ аргачлалын 3.1.2, 3.3.2-т заасны дагуу тусгай зөвшөөрлийн үнэлгээг тооцсон бол тусгай зөвшөөрлийн талбайн нэгж нөөцөд ногдох үнэлгээг тооцон, хэсэгчлэн шилжүүлж буй талбайн нөөцийн хэмжээгээр үржүүлэн хэсэгчлэн шилжүүлэх талбайн үнэлгээг гаргана.

3.9.Энэ аргачлалын 3.7-д заасан хэсэгчлэн шилжүүлж буй тусгай зөвшөөрлийн талбайн хил, байршил, булангийн цэгийн солбицлууд, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлсон баримт, шилжүүлж байгаа болон үлдэх талбайн хилийг тусгасан зураг болон шаардлагатай бусад баримтыг татвар төлөгч татварын албанд гаргаж өгнө.

3.10.Эрх бүхий байгууллагаас нөхөх олговрын зориулалтаар олгосон тусгай зөвшөөрлийн үнэлгээ нь нөхөх олговрын хэмжээнээс багагүй байна.

Дөрөв. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн үнэлгээ тооцох

4.1.Харилцан хамааралтай этгээдэд борлуулсан, шилжүүлсэн ашиглалтын тусгай зөвшөөрлийн үнэлгээг орлогод суурилсан аргаар тооцсон үнэлгээ ба татвар төлөгчийн мэдүүлсэн гэрээний үнийн аль өндрөөр тооцно.

4.2.Харилцан хамааралгүй этгээдэд борлуулсан, шилжүүлсэн ашиглалтын тусгай зөвшөөрлийн үнэлгээг татвар төлөгчийн мэдүүлсэн гэрээний үнэд үндэслэн тооцно.

4.3.Энэ аргачлалын 4.2-т заасны дагуу татвар төлөгчийн мэдүүлсэн гэрээний үнэ нь орлогод суурилсан аргын дагуу тооцсон үнэлгээнээс 20 ба түүнээс дээш хувиар бага байх тохиолдолд орлогод суурилсан аргаар тодорхойлсон дүнгээр тусгай зөвшөөрлийн үнэлгээг тооцно.

4.4.Ашиглалтын тусгай зөвшөөрлийн үнэлгээг орлогод суурилсан аргын дагуу тооцох боломжгүй тохиолдолд өртөгт суурилсан аргаар тооцно.

4.5.Энэ аргачлалын 4.4-т заасны дагуу тусгай зөвшөөрлийн үнэлгээг тооцохдоо харилцан хамаарлыг дараах байдлаар харгалзан үзнэ. Үүнд:

4.5.1.Харилцан хамааралтай этгээдэд борлуулсан, шилжүүлсэн бол өртөгт суурилсан аргаар тооцсон үнэлгээ ба татвар төлөгчийн мэдүүлсэн гэрээний үнийн аль өндрөөр;

4.5.2.Харилцан хамааралгүй этгээдэд борлуулсан, шилжүүлсэн бол татвар төлөгчийн мэдүүлсэн гэрээний үнэ нь өртөгт суурилсан аргын дагуу тооцсон үнэлгээнээс 20 ба түүнээс дээш хувиар бага тохиолдолд өртөгт суурилсан аргаар тодорхойлсон дүнгээр.

4.6.Татвар төлөгч нь ашиглалтын тусгай зөвшөөрлийн гэрээний үнэ болон энэ аргачлалд заасан тусгай зөвшөөрлийн үнэлгээ тооцох аргын дагуу тооцсон тооцоолол, холбогдох баримт бичгийг татварын албанд мэдүүлнэ.

4.7.Энэ аргачлалын дагуу татвар төлөгчөөс ирүүлсэн тусгай зөвшөөрлийн үнэлгээний тооцооллыг татварын алба хянана.

4.8.Ашигт малтмалын тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн тодорхой хэсгийг шилжүүлэх тохиолдолд энэ аргачлалын дагуу тооцсон үнэлгээнээс нэгж талбай эсхүл нэгж нөөцөд ногдох үнэлгээг тооцон, хэсэгчлэн шилжүүлж буй талбайн хэмжээ эсхүл нөөцийн хэмжээгээр үржүүлэн хэсэгчлэн шилжүүлэх талбайн үнэлгээг гаргана.

4.9.Энэ аргачлалын 4.1, 4.2-т заасны дагуу тусгай зөвшөөрлийн үнэлгээг тооцсон бол тусгай зөвшөөрлийн талбайн нэгж нөөцөд ногдох үнэлгээг тооцон, хэсэгчлэн шилжүүлж буй талбайн нөөцийн хэмжээгээр үржүүлэн хэсэгчлэн шилжүүлэх талбайн үнэлгээг гаргана.

4.10.Энэ аргачлалын 4.8-д заасан хэсэгчлэн шилжүүлж буй тусгай зөвшөөрлийн талбайн хил, байршил, булангийн цэгийн солбицлууд, нөөц, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлсон баримт, шилжүүлж байгаа болон үлдэх талбайн хилийг тусгасан зураг, нөөцийн дэвсгэр зураг болон шаардлагатай бусад баримтыг татвар төлөгч татварын албанд гаргаж өгнө.

Тав. Тусгай зөвшөөрлийн үнэлгээг өртөгт суурилсан аргаар тооцох

5.1.Хайгуулын тусгай зөвшөөрлийн үнэлгээг өртөгт суурилсан аргаар тооцохдоо геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хянасан хайгуулын ажлын жил бүрийн тайлан дахь хайгуулын ажлын зардлын нийлбэрийг аргачлалын 1 дүгээр хавсралтад байгаа хүснэгтийн дагуу холбогдох үржүүлэгчээр үржүүлж гаргасан дүн болон бусад зардлуудын нийлбэр дүнгээр тодорхойлно.

5.2.Энэ аргачлалын 5.1-д заасны дагуу тодорхойлсон үнэлгээнд туссан жил бүрийн хайгуулын зардлыг Үндэсний статистикийн хорооноос зарладаг Монгол Улсын хэрэглээний үнийн индекс /цаашид "ХҮИ" гэх/-ээр хөрвүүлж хайгуулын тусгай зөвшөөрлийн үнэлгээнд ашиглана.

5.3.Энэ аргачлалын 5.1-д заасны дагуу үнэлгээг тодорхойлохдоо энэхүү аргачлалын 1 дүгээр хавсралтад заасан маягыг баримтална.

Жишээ 1: XV-000000 тоот хайгуулын тусгай зөвшөөрөл нь 2013 оны 08 сарын 01-ний өдөр олгогдсон. Талбайн хэмжээ: 1684 га, хайгуулыг 6 жил хийсэн ба хайгуулын ажилд нийт 7,598.8 мянган төгрөг зарцуулсан. Талбайн хэмжээнд алтны таамаг нөөцийг тодорхойлсон. Үнэлгээг тооцохдоо Үндэсний статистикийн хорооны цахим хуудаснаас хэрэглээний үнийн индексийг ашигласан.

/мянган төгрөг/

Он	Хайгуулын ажлын тайланд тусгасан хайгуулын зардлын дүн	Хэрэглээний үнийн индекс /ХҮИ/	ХҮИ-ээр хөрвүүлснээр Нийт дүн	Үржүүлэгч	Бусад зардлын дүн /Тусгай зөвшөөрлийн төлбөр болон бусад/	Тусгай зөвшөөрлийн үнэлгээний дүн
2013 он					244.2	
2014 он	995.0	12.91%	1,346.2		488.4	
2015 он	938.3	5.88%	1,124.4		732.5	
2016 он	1,710.2	0.49%	1,935.5		2,441.8	
2017 он	1,865.5	4.62%	2,101.0		2,441.8	
2018 он	2,089.8	7.65%	2,249.7		2,441.8	
Дүн	7,598.8		8,756.8	1	8,790.5	17,547.3

Зургаа. Тусгай зөвшөөрлийн үнэлгээг зах зээлд суурилсан аргаар тооцох

6.1.Хайгуулын тусгай зөвшөөрлийн үнэлгээг зах зээлд суурилсан аргаар тооцохдоо харьцуулалтын шалгуур үзүүлэлтүүдээр үнэлэх матрицад оруулан нэгж талбайд ногдох үнэлгээг гаргаж, тухайн тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээгээр үржүүлэх зарчим ашиглана.

6.2.Хэрэв тухайн төрлийн ашигт малтмалын матрицыг тусгайлан гаргаагүй бол нүүрс, газрын тосноос бусад ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг үнэлэхэд

энэхүү аргачлалын 2 дугаар хавсралтад байгаа алтны матрицыг ашиглах бөгөөд шилжүүлж байгаа тал нь тухайн тусгай зөвшөөрөлд дурдагдсан бүх эрдсийн үнэлгээг алттай дүйцүүлэн хөрвүүлж тооцно.

6.3.Энэ аргачлалын 6.1-д заасан аргыг ашиглан хайгуулын тусгай зөвшөөрлийн үнэлгээг гаргах тохиолдолд хайгуулын талбайд илэрц бүхий ашигт малтмалын тухайн сарын дундаж үнийг³ үндэслэнэ.

6.4.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь онцгой нөхцөл байдал⁴ үүссэнээс бусад тохиолдолд уг алтны матрицыг 2 жил тутамд шинэчилж, шаардлагатай бол алтнаас бусад ашигт малтмалын төрлөөр нэмж матриц гаргаж болно.

6.5.Хайгуулын тусгай зөвшөөрлийн үнэлгээг 6.1-д заасан аргаар үнэлэх тохиолдолд дараах шалгуур үзүүлэлтүүдийг ашиглан аргачлалын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу матрицад оруулна. Үүнд:

6.5.1.геологийн шалгуур үзүүлэлтүүд:

6.5.1.а.газрын гадаргаас доош эрдэсжилтийн дээд орой хүртэлх гүн;

6.5.1.б.геологийн нөөцийн зэрэг;

6.5.1.в.агуулга;

6.5.1.г.ашигт малтмалын төрөл.

6.5.2.дэд бүтцийн шалгуур үзүүлэлтүүд:

6.5.2.а.талбайн хэмжээ;

6.5.2.б.хайгуулын талбайн ирээдүйн олборлолтод ач холбогдол бүхий дэд бүтцийн алслалт.

6.6.Геологийн болон дэд бүтцийн шалгуур үзүүлэлтүүдийг энэ аргачлалын 2 дугаар хавсралтад заасан маягт, онооны дагуу матрицын шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулан үзүүлэлт тус бүрийн хамаарах оноогоор дүгнэнэ.

6.7.Хайгуулын тусгай зөвшөөрөлд тусгагдсан ашигт малтмал бүрийн шалгуур тус бүрд холбогдох оноог тооцож, эдгээр онооны нийлбэрээр алтны үнэлгээний матриц дахь тохирох нэгж га талбайн үнэлгээг авна. Шилжүүлж буй ашигт малтмалын хайгуулын талбайн үнэлгээ нь матрицаас авсан тохирох нэгж га талбайн үнэлгээ болон тухайн тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээний үржвэр байна..

Жишээ 2: А ХХК-ийн XV-000000 тоот тусгай зөвшөөрөл Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт байрлалтай, 3 төрлийн ашигт малтмалын илрэлтэй, цайрын өндөр агуулгатай хүдэр нь газрын гадаргаас доош 75 метр, хар тугалганых 140 метр, цагаан тугалганых 350 метрийн гүнд байршсан. Талбайн хэмжээ 400 га, дэмжих дэд бүтцээс 40км зайтай. Хайгуулын ажлын үр дүнгээр цайр 1%, хар тугалга 3%, цагаан тугалга 6%-ын агуулгатай байсан. Б ХХК-д 40,000,000 /дөчин сая/ төгрөгөөр шилжүүлэхээр гэрээ байгуулаад байна.

³ Засгийн газрын 2016 оны 81 дүгээр тогтоолоор батлагдсан Биржийн болон зах зээлийн үнийн эх сурвалж дээр үндэслэн зарласан тухайн сарын дундаж үнэ.

⁴ Олон улсын зах зээл дээрх алтны үнэ огцом унах, есөх гэх зэрэг нөхцөл байдал бий болсон үед

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Цайр	Хар тугалга	Цагаан тугалга
Спот үнэ	\$/т	2,336	2,126	16,452
Спот үнэ	\$/кг	2.34	2.13	16.45
Агуулга – газар дээрээ	%	1.0%	3.0%	6.0%
Агуулга – газар дээрээ	гр/т	10,000	30,000	60,000
Алтны үнэ	\$/унц	1,514	1,514	1,514
Алтны үнэ	\$/кг	48,672	48,672	48,672
Алтны үнэд харьцуулсан үнийн харьцаа		0.000048	0.000044	0.000338
Агуулга алтанд дүйцүүлж хөрвүүлснээр /оноо/	гр/т	0.480 /7/	1.310 /6/	20.279 /0/
Төслийн талбай	400га			
Газрын гадаргаас доошхи гүн /оноо/	м	75 /0/	140 /0/	350 /1/
Нөөцийн зэрэг /оноо/		Таамагласан /3/	Таамагласан /3/	Таамагласан /3/
Дэд бүтцэд хүрэх зай /оноо/		40км /3/	40км /3/	40км /3/
Нийт оноо		13	12	7
Нэгжийн үнэлгээ	төг/га	39,800	53,067	119,400
Үнэлгээ	төг	15,920,000	21,227,000	47,760,000
НИЙТ ҮНЭЛГЭЭ	төг	84,907,000		

Аргачлалын 2 дугаар хавсралтад заасан маягт, онооны дагуу тооцсон матрицаар /Зах зээлийн арга/ тооцсон үнэлгээ 84.9 сая төгрөг болно.

Долоо. Тусгай зөвшөөрлийн үнэлгээг орлогод суурилсан аргаар тооцох

7.1.Энэ аргаар тооцсон тусгай зөвшөөрлийн үнэлгээ нь эрсдэл болон цаг хугацааны үнэ цэнийг харгалзан тооцсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ байна.

7.2. Мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг тооцохдоо Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар батлагдсан ордыг ашиглах техник эдийн засгийн үндэслэл /цаашид “ТЭЗҮ” гэх/ болон хайгуулын ажлын үр дүнгийн тайлангийн техник эдийн засгийн урьдчилсан тооцоо /цаашид “ТЭЗУТ” гэх/-г ашиглах ба ашигт малтмалын үнэ болон ашиглалтын зардлыг үнэлгээ тооцож буй оны түвшинд шилжүүлэн тооцно.

7.2.1. ТЭЗҮ, ТЭЗУТ нь олон хувилбараар тооцогдсон тохиолдолд энэ аргачлалын 7.1-д заасан мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ нь Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлын тэмдэглэлд туссан хувилбараас тооцогдоно.

Өнөөгийн үнэ цэнийг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

$$NPV = \sum_{t=1}^n CF_t \frac{1}{(1+r)^t} - CF_0$$

- NPV - Өсөн нэмэгдэж байгаа мөнгөн урсгалын өнөөгийн цэвэр үнэ цэнэ,
CF_t - тухайн t жилд орж ирэх цэвэр мөнгөн урсгал (элэгдэл хорогдлын шимтгэл болон цэвэр ашгийн нийлбэр дүн),
CF₀ - анхны хөрөнгө оруулалт (ТЭЗҮ, ТЭЗУТ-нд тусгасан уурхайн хөрөнгө оруулалт),

- n - төсөл хэрэгжих хугацаа буюу орд ашиглах хугацаа (ТЭЗҮ, ТЭЗУТ-нд тусгасан хугацаа, ордын ашиглалтын нөөцийг жилийн хүчин чадалд харьцуулан ашиглах хугацаагаар тодорхойлно)
- t - жилийн индекс
- r - эрсдэлийг шингээсэн хорогдуулалтын хувь хэмжээ (ТЭЗҮ, ТЭЗУТ-нд тусгасан дүнгээр тооцох бөгөөд дээд хязгаар нь 15 хувь байна.)

Жишээ 1: “AAA” нэртэй алтны шороон ордын нийт геологийн нөөц (ГН) нь 690 кг ашиглалтын үеийн хаягдал (АҮХ) 2 хувь байна. Хуулах хөрсний хэмжээ (ХХ) 1,865.0 мянган метр куб, олборлох элсний хэмжээ (ОЭ) 1,320.0 мянган метр куб байна. Алтны сорьц (АС) 918, металл авалт (МА) 90.5 хувь байхаар ТЭЗҮ-д тусгасан байна. Тухайн ордыг ашиглаж эхэлсэн эсэхийг тусгай зөвшөөрлийн талбай оршиж буй сум, орон нутгийн байгаль орчны байцаагчийн дүгнэлтийг үндэслэн тодорхойлно. Энэхүү дүгнэлтээр тухайн ордыг ашиглаж эхлээгүй байсан боловч ТЭЗҮ нь батлагдсан тул ордын үнэлгээг ТЭЗҮ-д тулгуурлан гүйцэтгэнэ. Тооцоонд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ)-ийг ТЭЗҮ-д тусгасан хувиар борлуулалтын орлогоос, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ)-ыг шаталсан хувиар (10 хувь, 25 хувь) тус тус тооцно.

Ашигт малтмалын төрөл (алт): Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтэд алтны ордын нийт геологийн нөөцийг бодитой В зэргээр 690.0 кг болохыг тодорхойлсон байна.

Ашигт малтмалын ашиглалтын нөөц (АН): ТЭЗҮ-д тусгаснаар:

Элсний нөөц 1,320.0 мян.м³

Хуулах хөрсний хэмжээ 1,865.0 м³

Алтны нөөц нь сорьц тооцоогүй, бохироороо /шлихээр/ 690.0 кг-аар тус тус тогтоогджээ. Борлуулах алтны хэмжээ буюу ашиглалтын нөөцийг тооцвол дараах байдалтай болж байна.

$АН=(ГН*АС)/1000*(100%-АҮХ) *МА$

$АН=(690кг*918)/1000*(100%-2%)*90.5%=561.78 кг$

Ашиглах хугацаа (АХ): ТЭЗҮ-д тухайн ордыг ашиглах хугацааг 3 жил гэж тодорхойлсон тул эдгээр дүнг тооцоонд ашиглана.

Хөрөнгө оруулалт (ХО): ТЭЗҮ-д ордын нийт хөрөнгө оруулалтын хэмжээг 6,300.0 сая.төг гэж тусгана..

Борлуулалтын орлого (БО): ТЭЗҮ-д 3 жилийн хугацаанд нийт 561.78 кг алт, эхний жилд 141.64 кг, 2 дахь жилд 216.6 кг, 3 дахь жилд 203.54 кг алт олборлон борлуулна.

1 грамм алтны үнийг 85.5 мян.төг-өөр тус тооцсон байна.

Жилийн борлуулалтын орлого (ЖБО)=жилд борлуулах алтны хэмжээ *алтны үнэ

$ЖБО1 =141.64 кг * 85.5.мян.төг/гр = 12,110.22 сая.төг$

$ЖБО2 =216.60 кг * 85.5.мян.төг/гр = 18,519.30 сая.төг$

$ЖБО3 =203.54 кг * 85.5.мян.төг/гр = 17,402.67 сая.төг$

Ашиглалтын хугацаанд олон нийт борлуулалтын орлого

$(АХОНБО)=ЖБО1+ЖБО2+....+ЖБОn$

$(АХОНБО)= 12,110.22 + 18,519.30 +17,402.67 = 48,032.19 сая.төг$

Цэвэр ашиг (ЦА): ТЭЗҮ-д Тухайн жилийн борлуулалтын орлогоос ашиглалтын зардал (АЗ) болон төлсөн татвар хураамжийг хасаж жилийн цэвэр ашгийг тооцно. Жил бүрийн ашиглалтын зардал ТЭЗҮ-д туссан тул тус дүнг ашиглана.

Жилийн цэвэр ашиг (ЖЦА)=БО-(АЗ+АМНАТ+ААНОАТ)

$$ЖЦА1 = 12,110.22 - (6,507.0 + 302.75 + 875.12) = 4,425.35 \text{ сая.төг}$$

$$ЖЦА2 = 18,519.30 - (10,057.0 + 462.98 + 1,549.83) = 6,449.49 \text{ сая.төг}$$

$$ЖЦА3 = 17,402.67 - (16,704.0 + 435.07 + 26.36) = 237.24 \text{ сая.төг}$$

Ашиглалтын хугацаанд олох нийт цэвэр ашиг

$$(АХОНЦА)=ЖЦА1+ЖЦА2+....+ЖЦАn$$

$$АХОНЦА = 4,425.35 + 6,449.49 + 237.24 = 11,112.08 \text{ сая.төг}$$

Нийт бэлэн мөнгөний урсгал (НБМУ):

$$НБМУ = \sum_{t=1}^n (ЦА + ЭХШ^4) - ХО = (4,425.35 + 250.0) + (6,449.49 + 530.0) + (237.24 + 290.0) - 6,300.0 = 5,882.08 \text{ сая. төг}$$

Эрсдэлийг шингээсэн хорогдуулалтын хувь (ХХ): ТЭЗҮ-д хорогдуулах хүүгийн түвшинг 10%-иар тооцсон байна.

Өнөөгийн цэвэр үнэ цэнэ (ӨЦҮЦ)

$$NPV = \sum_{t=1}^n CF_t \frac{1}{(1+k)^t} - CF_0$$

$$= \sum_{t=1}^3 \left(4,675.35 \frac{1}{(1+0.1)^1} + 6,979.49 \frac{1}{(1+0.1)^2} + 527.24 \frac{1}{(1+0.1)^3} \right) - 6,300.0$$

$$= 4,114.6 \text{ сая. төг}$$

Татвар ногдох орлого (ТНО):

$$ТНО = \text{ӨЦҮ} = NPV$$

$$ТНО = 4,114.6 \text{ сая.төг}$$

Ногдуулсан татвар (НТ):

НТ = (ТНО – Хасагдах зардлууд) x Эрх борлуулсны орлогод ногдуулах татварын хувь

$$НТ = (4,114.6 - X) * 10\% = Y$$

Энэхүү ашиглалтын тусгай зөвшөөрлийг шилжүүлэхэд эрх борлуулсны орлогоос У төгрөгийн ААНОАТ суутган тооцож, төсөвт төлнө.

Найм. Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг борлуулах, шилжүүлэхэд албан татварын ногдлыг тодорхойлох.

8.1.Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг борлуулах, шилжүүлэхэд албан татвар ногдуулах орлогыг тодорхойлоход Сангийн сайдын 2019 оны 302 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын


⁴ Элэгдэл хорогдлын шимтгэл

тусгай зөвшөөрөл борлуулсан, шилжүүлсний орлогод албан татвар ногдуулах журам”-ыг баримтална.


8.2. Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн үнэлгээг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 30.4-т заасны дагуу эцсийн эзэмшигчийн эцэслэн тооцсон эзэмшлийн хувиар үржүүлж татварын ногдлыг тодорхойлно.

8.3. Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшигч хуулийн этгээдээс эцсийн эзэмшигч хүртэлх үргэлжилсэн хэлхээ холбооны үе шат бүрд харгалзах хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн хувийг хооронд нь үржүүлж энэ аргачлалд заасны дагуу тухайн тусгай зөвшөөрлийн эцсийн эзэмшигчийн эзэмшлийн хувийг тооцно.


Жишээ 1. Татвар ногдуулах тохиолдол




Жишээ 2. Татвар ногдуулахгүй тохиолдол




Жишээ 3. ААНОАТ-ын тухай хуулийн 30.7-д заасан тохиолдол



Жишээ 4. ААНОАТ-ын тухай хуулийн 30.8-д заасан тохиолдол



Жишээ 5. ААНОАТ-ын тухай хуулийн 30.9-д заасны дагуу татвар ногдохгүй тохиолдол





Монголын Татварын Алба

Сангийн сайдын 2019 онб/02 дугаар тушаалаар
батлагдсан аргачлалын 1 дүгээр хэвсрэлт

МАЯГ ТЗ-01

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ҮНЭЛГЭЭГ ӨРТӨГТ СУУРИЛСАН АРГААР ТОДОРХОЙЛОХ МАЯГТ

Өртөгт суурилсан аргад ашиглах үржигдэхүүн

Нөөцийн зэрэг	С	Р	Тодорхойгүй
Харгалзах үржвэр	1.8	1	0.5

No	Хайгуул хийгдсэн он	Тусгай зөвшөөрөл анх олгосон огноо	Талбайн хэмжээ	Хайгуулын ажлын тайлангийн мэдээлэл			Үржигдэхүүн		Татвар ногдуулах дүн
				Хайгуулын ажлын тайланд тусгасан хайгуулын зардлын дүн	Хөрвүүлэх фактор (ХҮИ-хэрэглээний үнийн индекс)	Зардлын өнөвгийн үнэ цэнэ	Үржвэр	Нийт	
1									
2									
3									
Хайгуулын тусгай зөвшөөрлийн эрхийг шилжүүлсний орлогоос татвар ногдуулах дүн									
Татварын дүн									
Татварын албаны хяналтын хэсэг:									

Тооцооллыг гүйцэтгэсэн ХХК-г төлөөлж: Тооцоолол хийсэн огноо:
Захирал / /

Нягтлан бодогч: / /
гарын үсэг гарын үсэг

Тооцооллыг хянасан: Татварын улсын байцаагч, мэргэжилтэн / /
Хянасан огноо:

Тооцооллыг хянасан: Эрдэс баялгийн асуудал хариуцсан нэгжийн дарга / /
Хянасан огноо: гарын үсэг



Монголын Татварын Алба

Сангийн сайдын 2019 оны 502 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын 2 дугаар хавсралт

МАЯГ ТЗ-02

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ҮНЭЛГЭЭГ ЗАХ ЗЭЭЛД СУУРИЛСАН АРГААР ТОДОРХОЙЛОХ МАЯГТ

Зах зээлд суурилсан аргад ашиглах алтны матриц

Харгалзах оноо	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16
Төгрөг	200,000	185,733	172,467	159,200	145,933	132,667	119,400	106,133	92,867	79,600	66,333	53,067	39,800	26,533	13,267	1,000

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ҮНЭЛГЭЭГ ЗАХ ЗЭЭЛД СУУРИЛСАН АРГААР ТОДОРХОЙЛОХ МАЯГТ

Метр	1. Газрын гадаргаас эрдсийн дээд цэгт хүрэх гүн		2. Геологийн нөөц, баялгийн зэрэг		3. Агуулга (гр/тонн)		4. Дэмжих дэд бүтцэд хүрэх зай		Үнэлж буй тусгай зөвшөөрөл								
	Оноо	Бодит оноо	Нөөц / Баялаг	Оноо	Бодит оноо	гр/т	Оноо	Бодит оноо	Км	Оноо	Бодит оноо	Оноонд харгалзах матриц	Талбайн нийт хэмжээ	Нийт үнэлгээ	Хасагдах зардал	Татвар ногдуулах дүн	Татварын дүн
0-50 м	0		Баттай	0		0.1-0.5	7		Зэргэлдээ < 5 км	1							
50-100 м	1		Бодитой	1		0.5-1.0	6		Ойролцоо (5-30 км)	2							
100-200 м	2		Боломжтой	2		1.0-1.5	5		Дунд зэрэг зайтай (30-80 км)	3							
200-500 м	3		Илрүүлсэн, Баримжаалсан, Таамагласан	3		1.5-2.0	4		Хол (80-150 км)	4							
>500 м	4		Тодорхойгүй	4		2.0-3.0	3		Алслагдсан (>150 км)	5							



Сангийн сайдын 2019 оны 302 дугаар тушаалаар
батлагдсан аргачлалын 3 дугаар хавсралт

Маягт ТЗ-03

Монголын Татварын Алба

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ҮНЭЛГЭЭГ ӨНӨӨГИЙН ҮНЭ ЦЭНЭЭР ТООЦОХ МАЯГТ

Тооцоолол нь мэдээлэлд үндэслэнэ:

1. Ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл.
2. Ордын нөөцийн тайланд тусгасан техник, эдийн засгийн урьдчилсан тооцоо.
3. Тодорхой хугацаанд ашигласан ордын хувьд ТЭЗҮ болон нийт нөөцөөс олборлосон нөөцийг хассан дүн /ашигласан баримт бичгийн урд дугаарыг дугуйлна, ордын төрөл нөхцөлөөс хамаарч маягтад үзүүлэлт нэмж оруулж болно./

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж /ашигт малтмалын төрлөөс хамаарч тохирох нэгжийг бичнэ/	Нийт	Ашиглалтын жилүүд (n+...)				Татварын албаны хяналтын хэсэг
			0	1	2	3	
Геологийн үзүүлэлтүүд							
Нийт хөрсний хэмжээ	м ³						
Нийт хүдрийн нөөц	тн						
Хөрс хуулалтын коэффициент	м ³ /тн						
Нийт уулын цул	м ³						
Олборлолтын үзүүлэлтүүд							
Нийт ашиглах хугацаа	Жил						
Хаягдал	%						
Бохирдол	%						
Нийт хуулах хөрсний хэмжээ	м ³						
Ашиглалтын нөөц	тн						
Эдийн засгийн үзүүлэлтүүд							
Нийт хөрөнгө оруулалт	мян.төг						
1 тн бүтээгдэхүүний борлуулалтын	мян.төг/тн						
Нийт борлуулалтын орлого	мян.төг						

Нийт үйл ажиллагааны зардал	Мян.төг						
Үүнээс элэгдэл хорогдлын шимтгэл	Мян.төг						
Татварын өмнөх ашиг	Мян.төг						
Ашгийн татвар	Мян.төг						
Татварын дараах ашиг	Мян.төг						
Мөнгөн урсгал	Мян.төг						
Өнөөгийн цэвэр үнэ (NPV)	Мян.төг						
Дотоод өгөөжийн хувь (IRR)	%						
Хөр.оруулалтаа нөхөх хугацаа	Жил						
Татварын хувь	%						
ААНОАТ-ын тухай хуулийн 30.3-т заасан хасагдах зардлын дүн	Мян.төг						
Албан татвар ногдуулах дүн	Мян.төг						
Ногдох татварын дүн	Мян.төг						

Тооцооллыг гүйцэтгэсэн ХХК-г төлөөлж:

Тооцоолол хийсэн огноо:.....

Захирал / /
гарын үсэг

Нягтлан бодогч: / /
гарын үсэг

Тооцооллыг хянасан:
Татварын улсын байцаагч, мэргэжилтний нэр / / Хянасан огноо:
гарын үсэг

Тооцооллыг хянасан:
Эрдэс баялгийн асуудал хариуцсан нэгжийн дарга / / Хянасан огноо
гарын үсэг

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БОРЛУУЛАХ, ШИЛЖҮҮЛЭХЭД БҮРДҮҮЛЭХ
БАРИМТ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ**

- 1.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын том татвар төлөгч хариуцсан нэгжид хандаж гаргасан албан хүсэлт;
- 2.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл шилжүүлэхэд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу эрх борлуулсны орлогод ногдуулсан албан татварыг харилцагч татварын албаны холбогдох дансанд төлсөн баримтын хуулбар; /Төлбөрийн баримтын тэмдэглэлд: тоот ашигт малтмалын тусгай зөвшөөрөл шилжүүлсэн гэсэн утгыг бичсэн байна/
- 3.Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг шилжүүлэх гэрээний нотариатаар баталгаажуулсан хувь;
- 4.Хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийг шилжүүлэх замаар тусгай зөвшөөрлийг борлуулсан, шилжүүлсэн тохиолдолд нийт хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн үнэлгээнд эзлэх тусгай зөвшөөрлийн үнэлгээг харуулсан баримт;
- 5.Тусгай зөвшөөрөл шилжүүлэгч болон шилжүүлэн авагч аж ахуйн нэгжийн гэрчилгээ, дүрмийн нотариатаар баталгаажуулсан хувь;
- 6.Эцсийн эзэмшигч хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийг шилжүүлэх замаар тусгай зөвшөөрлийг борлуулсан, шилжүүлсэн тохиолдолд үргэлжилсэн хэлхээ холбоонд хамаарах аж ахуйн нэгжийн эзэмшиж буй хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн талаарх үнэлгээ, мэдээлэл;
- 7.Тусгай зөвшөөрөл шилжүүлэгч талын сүүлийн жилийн болон улирлын иж бүрэн санхүүгийн тайлан, биет бус хөрөнгийн дансны задаргаа /тусгай зөвшөөрөл тус бүрээр/ буюу тусгай зөвшөөрөл бүртгэсэн дансны мэдээлэл, Хайгуул, үнэлгээний хөрөнгө дансны задаргаа, Уурхайн хөрөнгө дансны задаргаа; /Сангийн сайдын 2016 оны 409 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт/
- 8.Шилжүүлж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн хуулбар, хавсралтын хамт;
- 9.Хайгуулын тусгай зөвшөөрөл шилжүүлэх үеийн хайгуулын ажлын тайлангууд, Хайгуулын ажлын зардлын дүнгийн задаргаа;
- 10.Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хувьд уулын ажлын тайлан, ТЭЗҮ, ашиглалтын тусгай зөвшөөрөл шилжүүлэх үеийн үлдэгдэл нөөцийн хэмжээг харуулсан баримт тооцоо, Ашигт малтмалын газрын даргын ордын нөөцийг хүлээн авч, бүртгэсэн тухай тушаалын нотариатаар баталгаажуулсан хувь;
- 11.Энэ аргачлалд заасан аргаар албан татвар ногдуулах орлогыг тодорхойлсон тооцоолол.

**АШИГТ МАЛТМАЛ, ЦАЦРАГ ИДЭВХТ АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ
ХАЙГУУЛ, АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БОРЛУУЛСАН ШИЛЖҮҮЛСНИЙ
ОРЛОГОД АЛБАН ТАТВАР НОГДУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 30.2-т заасан эцсийн эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийг борлуулах, шилжүүлэх замаар Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу олгосон ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг бүрэн буюу хэсэгчлэн борлуулах, шилжүүлэхтэй холбогдон олсон орлогод албан татвар ногдуулахад оршино.

1.2. Энэ журамд заасан “эцсийн эзэмшигч” гэж Татварын ерөнхий хуулийн 6.1.48-д тодорхойлсон ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдийн 30 болон түүнээс дээш хувийн хувьцаа, хувь оролцоо, эсхүл саналын эрхийг өөрөө, эсхүл нэг болон түүнээс дээш үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий хуулийн этгээдээр төлөөлүүлэн эзэмшдэг, саналын эрхийг төлөөлүүлэн хэрэгжүүлдэг, эсхүл ногдол ашгийг хүлээн авах эрхтэй этгээдийг ойлгоно.

Хоёр. Албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

2.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 30.6-д заасны дагуу Сангийн сайдын 2019 оны 302 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн үнэлгээ тооцох, татварын ногдлыг тодорхойлох аргачлал”-ын дагуу тодорхойлсон эрхийн үнэлгээнд үндэслэн албан татвар ногдуулах орлогыг тооцно.

2.2. Энэ журмын 2.1-д заасны дагуу тооцсон орлогыг доор дурдсан тохиолдолд албан татвараас чөлөөлнө:

2.2.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 30.7-д заасны дагуу тооцоход бага дүнтэй орлого;

2.2.2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 30.9-д тодорхойлсон орлого.

2.3. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 30.7-д заасан эрх борлуулсан, шилжүүлсний орлогыг эцсийн эзэмшигчийн хувьцаа, хувь оролцоо, саналын эрх эзэмшиж буй тухайн этгээдийн ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл, газар эзэмших, ашиглах эрхийн үнэлгээний нийлбэрээр тооцно.

2.4. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 30.2-т заасны дагуу хэсэгчлэн борлуулах, шилжүүлэхтэй холбогдон олсон орлогыг тухайн эцсийн эзэмшигчийн үргэлжилсэн 12 сарын хугацаанд борлуулсан, шилжүүлсэн хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн нийлбэрээр тооцно.

2.5. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 30.8-д заасныг Татварын ерөнхий хуулийн 26.10, 26.11, 26.12-т заасны дагуу татварын албанд бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэн хэрэгжүүлнэ.

2.6. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 30.9-д заасан чөлөөлөлтийг Татварын ерөнхий хуулийн 26.12-т заасны дагуу татварын албанд бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэн эдлүүлнэ.

Гурав. Албан татвар ногдуулах орлогыг тооцоход хасагдах зардал

3.1. Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн үнэлгээнээс Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.7, 30.3-д заасан баримтаар нотлогдох зардлуудыг хасаж татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

3.2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.7.1, 30.3.1 дэх заалтыг төлбөр төлснийг нотолсон холбогдох төрийн байгууллагын баримт, эсхүл тухайн төрийн байгууллагыг төлөөлөх эрх бүхий этгээдийн албан тодорхойлолтыг үндэслэн хэрэгжүүлнэ.

3.3. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.7.2, 30.3.2-т заасан баримтаар нотлогдох төлбөрт хамаарах татварыг ногдуулан төлөөгүй тохиолдолд уг төлбөрийг албан татвар ногдох орлогоос хасаж тооцохгүй.

Дөрөв. Албан татвар төлөх, тайлагнах

4.1. Эцсийн эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийг борлуулах, шилжүүлэх замаар Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу олгосон Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг бүрэн буюу хэсэгчлэн борлуулах, шилжүүлэхтэй холбогдон олсон орлогод ногдох татварыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 30 дугаар зүйл, Татварын ерөнхий хуулийн 26.10, 26.11, 26.12-т заасны дагуу төлж, тайлагнана.

--oo00oo--